


- Төслийн товч танилцуулга
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт
- Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт
- Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Удирдлага зохион байгуулалт төлөвлөгөөний биелэлт
- Олон нийтэд тайлагнах хуваарь төлөвлөгөөний биелэлт
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр түүний үр дүнг тайлагнах хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Хун Хуа ХХК”
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019012147
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Тоосгоны үйлдвэрлэл
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Налайх дүүрэг 3-р хороо Их уурхай Харганат -2 задгай
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Г. Уранбилэг: Утас 80696980 Цахим хаяг: Gonchig_urnaa0510@yahoo.com
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлтийн дугаар	2011 оны 06 дугаар сарын 02 ны өдөр №08
	7. ТЭЗҮ баталсан огноо	2010 оны 06 дугаар сарын 17-ны өдөр № 07-01 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдөр № 07-01
	8. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	Коронавирусээс шалтгаалж өмнө онд олборлолт, үйлдвэрийн үйл ажиллагаа явагдагүй
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ		
1.2	1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дугаар хүчинтэй хугацаа	-Барилгын материалын үйлдвэрлэл 3.1.1 керамик тоосгоны үйлдвэрлэл №БМУ 283/17 5 жил /2017/05/28 ---2022/05/28/
	2. Галын дүгнэлтийн огноо,	2019.04.01
	3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан	Баталсан: БОНХАЖЯам 2016 он
	4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан	Баталсан: БОНХАЖЯам 2016 он
	5. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2018 оны 05 сарын 20-ний өдөр № 20

Зураг 1.



1.1. Төслийн хүчин чадал

Төслийн хүрээнд Уул уурхайн яам, Ашигт малтмалын газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 19-02-08 тоот дүгнэлтээр зөвшөөрч баталсан Ар-харганат тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах, техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсанаар жилд 10 мян.м³ шавар, 3 сая.ш тоосго, ашиглалтын хугацаанд жилд дунджаар 2700м³ хөрс хуулж, 10 000м³ шавар олборлож, 34 жил ажиллахаар тусгасан байна.

ЭБМЗ-ийн 2018 оны 11 сард баталснаар нийт уурхайн хил хязгаар доторхи геологийн нөөц В \бодитой\ зэргээр 340,605 мян.м³ буюу 497.68 мян.тн, С \боломжтой\ зэргээр 218.922 мян.м³ буюу 439.415 мян.тн гэж тооцсон.

Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн орчны тойм зураг



Хун-Хуа ХХК-ийн тоосгоны шаврын ордыг ашиглаж тоосго үйлдвэрлэж буй үйлдвэр нь Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Их Уурхайн Харганат-2 ын задгайд байрладаг.

Төслийн хэрэгжих өнөөгийн байдал нь: Их Уурхайн Харганат-2 задгайд байрлах тоосгоны шаврын орд нь Улаанбаатар хотын Налайх дүүрэгт харъяалагдана.

Налайх дүүрэг нь дэд бүтцийн хувьд харьцангуй сайн. Нийслэлтэй засмал замаар холбогдсон, зүүн бүсийг хангах цахилгаан дамжуулах өндөр хүчдлийн шугам, радио релей ба холбооны шугам, агаарын ба засмал зам дайран өнгөрдөг.

Уур амьсгал: Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хүйтэн нь 1-р сарын дундаж агаарын температур -27°C , хамгийн дулаан нь 7-р сард, агаарын дундаж температур нь 17.1°C салхины хурд хаврын 4 сард их 1,4-6,3 м/с, намар 10 сард 0,8-4,7 м/с жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75 % хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Хур тундас жилд дундажаар 240 мм ордог.

Гадаргын ус усан хангамж: Шаврын орд тоосгоны үйлдвэрийн байрлаж буй 3-р хорооны нутаг дэвсгэрт булаг шанд гол горхи байхгүй. Тус тоосгоны үйлдвэр нь хэрэгцээний усаа өөрийн эзэмшлийн гүний худагын усаар хангадаг.

Геологи нь: Ордын талбайн хувьд Цэрдийн настай шаравтар өнгийн шавар элс сул цементлэгдсэн үеэс тогтсон байдаг.

Ашиглалт хийгдэж буй талбайн гадаргуун өндөршил нь 1430-1440 м-ийн хооронд хэлбэлздэг. Шаврын давхарга нь шаравтар өнгийн шавранцар, шаварлаг хэсгээс тогтсон 168м зузаантай, 78-182 м өргөнтэй. Шаравтар өнгийн 3,4-2,0 м-ийн зузаантай шаврын үе нь барилгын үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болно. Тухайн орд нь ой мод, намаггүй, нэвтрэлт сайн, гадаргуугийн рельеф жигд тэгш тогтоцтой нь ордыг ил аргаар ашиглах боломжтой таатай нөцлүүдийг бүрдүүлдэг.

Орд нь ургамалын үндэс бүхий өнгөн хөрс нь жижиг ширхэгтэй шавар, элсэнцэр, сул цементлэгдсэн конгломераттын болон нүүрсний үе бүхий төрлөөс бүрдэнэ.

Хөрс: Монгол орны хөрс газарзүйн мужлалаар хангайн Их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтий Дэд бүсийн Хэнтий захын хөрсний тойрогт хамаарагдах бөгөөд энэхүү бүс нутаг нь ойт хээрийн бүст хамаарагдана. Тухайн ордын талбайд

“Ану сервис” ХХК газрын төлөв байдал чанарын хянан баталгаа 2020 онд хийж гүйцэтгэсэн. Уг хөрсний судалгаанаас үзэхэд тухайн ордын талбайд хар хүрэн хөрс зонхилон тархсан байна.

Хөрсний бүтцийн өөрчлөлт хөрсөнд агуулагдах тэжээлийн бодисын агуулгыг үзэх зорилгоор дээж авч шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс үзэхэд мэдэгдэхүйц ялзмагийн агууламж багассан.

Ургамлан нөмрөг: төслийн талбай нь Ургамал газар зүйн мужлалын хувьд Евро Азийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн чийглэг хэв шинжийн Өвөр байгалийн Туул-Бархын мужд хамаарагдана. Ургамалын бүлгэмийн хувьд шарилжалаг өвст бүлгэмдэлд багтана. Ил аргаар олборлолт явуулахад хөрс эвдрэлд их хэмжээгээр эвдэрдэг ч ухсан ам, нүх хооронд байгалийн унган төрхөөрөө байгаа талбай багагүй хэмжээтэй байна. Мөн тухайн орчинд нилээд чийглэг учир ургамлын төрөл зүйлийн хувьд нилээд баялаг юм. Үйл ажиллагаа явуулж байгаа талбай нь талхлагдаж ургамлан нөмрөггүй болж хог ургамал ихээр тархсан байна.

Нийгэмд нөлөөлөх байдал: Тоосго үйлдвэрлэх шавар олборлох явцад гарах тоос тэнд ашиглаж буй тоног төхөөрөмж машин техникийн дуу чимээ нь ойролцоо нутаглаж буй ард иргэдэд амьтад нөлөө үзүүлэх нөхцөлтэйгээс амьтад даажих нөхцлийг бүрдүүлдэг.

Хаягдалын менежмент: Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах шингэн болон хатуу хог хаягдлыг төсөл хэрэгжүүлэгч нь тодорхой заагдсан дүрэм стандартын дагуу цуглуулан нэг цэгт төвлөрүүлэн хадгалж зайлуулах үүрэгтэй. Хатуу хог хаягдлыг салхины доод талд зорлуулалтын саван болон хогийн сараа хийж төрөлжүүлэн ялгаж ачуулах ашиглаж болох зүйлийг 2 дахь түүхий эдийн цэгт тушаах шаардлагатай.үүнтэй уялдсан хог хаягдлын менежментийн төлөвлөгөө хийж дүүргийн ТҮГ хийсэн хог хаягдлын гэрээний дагуу ачуулах ахуйн хэрэглээний бохир усыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүйгээр зайлуулах усыг хэмнэж эргүүлэн ашиглах бага оврын био реакторт бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглах шаардлагатай.

2020-2021 онуудад Дэлхийд шинэ төрлийн короновирус гарсантай холбоотойгоор хил хааж Хятадаас ирдэг инженерүүд ирэх боломжгүй болсоноор

тухайн тоосгоны үйлдвэр ямар нэгэн олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй болно.

2022 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг батлуулах гэрээ хийгдсэн боловч батлагдаж гараагүй 2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тоосгоны үйлдвэрлэлийн ажил хийгдсэн.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Сөрөг нөлөөлөлийг зөв тодорхойлсноор байгаль орчин, хүрээлэн буй орчинд учрах хохирол, эвдрэх, сүйрэхээс хамгаалах, урьчилсан сэргийлэх чухал ач холбогдолтой. Тоосго үйлдвэрлэх шаврыг олборлохдоо хөрс хуулах, олборлолт явуулахдаа уулын хүнд механизм ашигладаг. Иймээс газрын гадаргын геологийн тогтоцыг эвдэж, өөрчилдөг мөн түүхий тоосго шатаахад үүсэх агаарын бохирдолын сөрөг нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна. Шаврын ордын үйл ажиллагааны гол зорилго нь байгалийн баялагийг ашиглахад чиглэсэн байдаг тул нөлөөлөл нь шууд, буцалтгүй шинжтэй юм. Тоосгоны үйлдвэрийн орчимд урсгал ус, гол горхи байхгүй, шаврын олборлолтын давхаргад гүний усны илрэлгүй тул байгаль орчны чанарын өөрчлөлтөнд өртөхөд нөхцөл бага. Харин хөрсний элэгдэл эвдрэл агаарын бохирдол бий болох шууд нөлөөлөлтэй. Энэ нөлөөлөл нь хөрсөнд дунд зэрэг урт хугацаагаар, буцалтгүй нөлөөлөх магадлалтай. Үйлдвэрийн технологийн бүх үе шатанд хөрс хуулах овоолго хийх олборлох ачих, тээвэрлэхэд тоос богино хугацаагаар гарах бөгөөд тоосго үйлдвэрлэх явцад баюунаас гарах утаа нь ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх, ойр орчимын хөрсний бүтэц өөрчлөгдөх улмаар ургамлын бүрхүүлд нөлөөлж болох талтай.

Эдийн засаг, нийгмийн асуудлын хувьд шаврыг олборлож тоосго үйлдвэрлэх үйлдвэрлэл нь улс орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах, тодорхой тооны хүмүүсийг улирлаар ажлын байраар хангадаг. Эдгээр нь **шууд** бөгөөд **урт хугацааны** эерэг нөлөөлөлд хамаарна.

Бусад нөлөөлөл

Энэ төрлийн нөлөөлөл газар ашиглалт болон ахуйн хаягдалтай холбогдолтой зүйлүүдийг оруулав. Газар ашиглалтын холбоотой нөлөөлөлд хөрсний элэгдэл, байгалийн гамшгийг (хүчтэй салхи, үер, газар хөдлөл г.м) оруулдаг байна. Хаврын улиралд салхи ихтэй заримдаа 16 м/с-ээс дээш хүчтэй салхилдаг нь шавар олборлож, тоосго үйлдвэрлэх үйл ажиллагааны үед хөрснөөс сулласан их хэмжээний тоос шороо босох, ойр орчимдоо хөрсний элэгдэл, эвдрэлийг улам хүчтэй болгох нөхцөлтэй.

Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал

Уурхайн үйл ажиллагааны улмаас 2023 онд ил уурхай, зам, хөрсний овоолго зэрэг талбайд ямар нэгэн эвдрэл үүсгэж олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй.

Ордыг ашигласнаар газрын гадаргууг өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, дүүргийн гидрогеологийн горимыг өөрчилдөг.

Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Шаврын ордыг олборлох, хөрс тээвэрлэх явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий гэх мэт/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын хими болон физик шинж чанарт нь сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.

Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос гарах нөхцөл бүрддэг. Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх, түүхий эдийг бутлах, ачих зэрэг технологийн процессийн явцад салхитай нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг дурдвал:

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Уурхайд хөрсний овоолго хийх, шавар, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана

- Шавар, хөрс тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших

Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл

- Ногоон байгууламжийн усалгаа зэрэг усны хэрэглээг шүүрлийн усаар хангах учир газрын гүний усны нөөц, горимд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.
- Аадар борооны үед тус талбайд түр зуурын үерийн ус бууж талбай дахь хөрс, элс, хатуу шингэн хог хаягдал, хагшаас зэргийг урсгаж гадаргын усыг бохирдуулж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас усан орчинд шууд бусаар нөлөөлнө.
- Газар шорооны ажлын үед газрын доорх ус агуулсан үеийг ухаж хөндөх нь газрын доорх усыг бохирдуулах магадлалтай.

Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
- Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
- Төслийн түүхий эд, материалыг зөөх тээвэрлэх,
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,
- Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх явцад аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх явцад ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулал олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Нөхөн сэргээлт хийж буй байдал

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардал мян.төг	Баримтлах хууль, стандарт аргачлал
Агаар				
Эвдэрсэн газар болон сул хөрстэй талбай овоолгуудаас хийссэн тоос шороо салхиар дамжин ургамал улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Уурхайн дотоод тээврийн зам, талбайг услах, чийглэх Овоолгыг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэнд ашиглах	2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.		MNS 4585:2007 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5077:2001 “Ажлын байрны агаарын чанар” MNS 5885:2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”
Үйлдвэрийн болон олборлолтын үйл ажиллагааны туршид ашиглагдах тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмуудаас нүүрстөрөгчийн дутуу исэл; (CO), нүүрстөрөгчийн давхар исэл (CO2), азотын ислүүд (NOx), хүхрийн оксид (SOx) болон тоосжилт ялгарч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Шаталтаас агаарт үүсэх хорт хийн ялгаралтыг багасгахын тулд янданд шүүлтүүр суурилуулах, тохиргоо хийх, техникийн горимыг сайтар мөрдөх Техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх, техник тоног төхөөрөмжийн тохиргоо, битүүмжлэлийг сайтар хийх; ОХШХөтөлбөрийн дагуу агаарын чанарын шинжилгээг тогтмол хийж, түүний үр дүнд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.	-	Монгол улсын агаарын тухай хууль, 2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга Агаарын тухай” хууль: “Байгаль орчныг хамгаалах тухай” MNS (ISO) 4226:2000 “Агаарын чанар”, MNS 4585:2008 “Агаар орчны чанарын үзүүлэлт”

<p>Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс орчны агаарт бохирдол үүсч, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх</p>	<p>Хог хаягдлыг ангилан ялгаж, тогтоосон цэгт тогтмол хугацаанд зайлуулах, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох</p>	<p>2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>	<p>-</p>	
<p>Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүссэн тоосжилт болон хорт хий нь ажлын байрын нөхцөлийг муутгах, улмаар ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хэрэгслээр үзүүлэх</p>	<p>Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах; Хүн нэг бүрийг хувийн хамгаалах хангах (маск, баг, хошуувч г.м) Шавар нунтаглах суурь машины тоос сорох төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг тогтмол хийх, тоосжилтыг бууруулах нэмэлт систем суурилуулах; Хордлого тайлах хүнс, эмээр хангах</p>	<p>2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>	<p>-</p>	
<p>Газрын хэвлий</p>				
<p>Шавар олборлоход үед хөрс хуулах, газрын хэвлий ухагдаж, эвдрэх, нүх, овоолго үүсэх, барилга байгууламж барих, хүн, машин техникийн хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвч талхлагдаж, эвдрэлд орох, ургамлан нөмрөг устгах сөрөг нөлөөлөл үзүүлэх</p>	<p>Газрын эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгахад анхаарч, үйл ажиллагаагаа нарийн төлөвлөх, шаардлагагүй тохиолдолд шинээр газар хөндөхгүй байх Үйлдвэрийн, орд хүрэх замыг механизмын даацад тохируулан засаж, сайжруулах Механизмуудыг тогтсон 1 маршрутаар явуулах Үйлдвэрийн орчмын өнгө үзэмжийг сайжруулахын тулд бут сөөг тарьж,цэцгийн мандал хийж</p>	<p>2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан боловч олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй.</p>	<p>-</p>	<p>MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” - MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”</p>

	тохижуулах			
Түлш шатахуун хадгалах газрын орчимд шатахуун асгарах тохиолдолд газар, хөрс бохирдуулах	Түлш шатахууныг буулгах, ачих, машин техникийг цэнэглэх талбайн орчимд хур борооны ус зайлуулах сувгийг байгуулах; Үерийн усны далан сувгийг зураг төслийн дагуу байгуулах, хэвийн ажиллагаатай байлгах;	2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.		
Гүний ус				
Үйлдвэрлэлд, ажиллагсдын ахуйн хэрэгцээнд ус хэрэглэснээс усны нөөц тодорхой хэмжээгээр хомсдох	Усны хэрэглээг хамгийн бага байлгахад анхаарч, нийт ажиллагсдыг усны зөв зохистой хэмнэлттэй хэрэглээний талаар сургалтанд хамруулах,	2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.	-	MNS 6148:2010. Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4236:2003 Усан хангамж – Хэрэглэгчдийн усаар хангагдах ба төвийн цэвэрлэх байгууламжийн техникийн нөхцлүүд Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны норм /2015 он БОАЖЯ-ны сайдын А/301-р тушаал/
Түлш шатахуун, шатах тослох материал, асгарч алдагдсанаас бороо	Шатах, тослох материал, түлш шатахуун асгарч алдагдахаас	2023 онд тоосго үйлдвэрлэх	-	

үерийн усны нөлөөгөөр хөрсний болон газрын доорхи ус бохирдох нөлөөтэй	сэргийлэх; Хог хаягдлаар хөрсний болон гүний ус бохирдохоос сэргийлэх.	ажиллагаа явуулсан.		
Хөрсөн бүрхэвч				
Тоосгоны шавар олборлолтын явцад хөрсний үржил шимт хөрсийг хуулж, хөрсөн бүрхэвч үгүй болно. Мөн үйлдвэрийн орчмын талбайн хөрсөн бүрхэвч машин техникийн хөдөлгөөнөөс болж талхлагдах нөлөөтэй	Үйлдвэрийн орчны талхлагдсан газрыг тэгшлэж, засаж, ургамалжуулах; Тоосгоны шавар олборлох үйл ажиллагаа явуулсны дараа биологийн нөхөн сэргээлтийг хийх	2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.	-	MNS 5918:2008. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага MNS 4918:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага MNS 4915:2000 Эвдэрсэн газарт тарималжуулалт хийхэд тавих ерөнхий шаардлага,
Ургамлан нөмрөг				
Үйлдвэрийн барилга байгууламж барих олборлолтын хөрс хуулалтын явцад ургамлан нөмрөг устгах Тоосжилт болон хорт утааны ялгаралт ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл учруулах	Ургамлан нөмрөг нь устаж үгүй болоогүй эрүүл газарт, ургамалжуулсан газруудад машин, техник оруулахгүй байх Эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээж, ургамалжуулах, зүлэгжүүлсэн талбайг дахин өртөхөөс урьдчилан хашаалах хэрэгтэй	2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.	-	“Байгалийн ургамлын тухай” хууль: MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”
Галын аюул				

<p>Аянга, цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах;</p>	<p>Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг байнгын бэлэн байлгах, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, тэмдэг тэмдэглэгээ тавих Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах Бүх төрлийн тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг хэмжиж баталгаажуулах Ажилчдыг гал түймрийг унтраах мэргэжлийн сургалтанд хамруулах</p>	<p>2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>	<p>-</p>	<p>Гамшгаас хамгаалах тухай” хууль: Заалт 27.1 “Галын аюулгүй байдлын тухай” хууль: Заалт 16-1, 2; Заалт 18-1, 2; Заалт 19-1, 2; Заалт 20-1, 2; Заалт 21-1, 2, 3;</p>
<p>Аянга, цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах;</p>	<p>Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг байнгын бэлэн байлгах, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, тэмдэг тэмдэглэгээ тавих Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах Бүх төрлийн тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг хэмжиж баталгаажуулах Ажилчдыг гал түймрийг унтраах мэргэжлийн сургалтанд хамруулах</p>	<p>2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>	<p>-</p>	<p>Гамшгаас хамгаалах тухай” хууль: Заалт 27.1 “Галын аюулгүй байдлын тухай” хууль: Заалт 16-1, 2; Заалт 18-1, 2; Заалт 19-1, 2; Заалт 20-1, 2; Заалт 21-1, 2, 3;</p>
<p>Нутгийн иргэд</p>				
<p>Оршин суугчдын суурьшлын хэсгийн</p>	<p>Орон нутгийн засаг захиргааны</p>	<p>2023 онд тоосго</p>	<p>-</p>	

<p>ойролцоо үйл ажиллагаа явуулж буй үед дуу чимээ, тоосжилтын түвшин нэмэгдэх</p>	<p>байгууллагатай хамтран ажиллаж, орон нутгийн иргэдийг үйлдвэрт авч ажиллуулах; Тоосгоны шавар олборлох болон Тоосгоны үйлдвэрийн үйл ажиллагааг явуулахдаа дуу чимээний холбогдох шалгуур үзүүлэлттэй нийцүүлж байх;</p>	<p>үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>		
<p>Сургалт</p>				
<p>Орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллагууд, нутгийн оршин суугчдад үйлдвэрийн ажиллагааны талаар тогтмол танилцуулж, үе шаттай сургалт зохион байгуулж байх;</p>	<p>Өөрийн үйл ажиллагааны талаар үе шаттай мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах: Ижил төрлийн үйлдвэрлэл эрхлэж буй үйл ажиллагаатай, үйлдвэрийн ажилчдыг танилцуулах сургалтанд хамруулах</p>	<p>2023 онд тоосго үйлдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>	<p>1000.0</p>	<p>Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан.</p>

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн явцад үүссэн орон зайг дотоод овоолго байгуулан хэсэгчлэн техникийн нөхөн сэргээлт хийсэн. Хөрсийг дотоод овоолгод хурааснаар гадаад овоолгын хөрсөнд дарагдах газрын хэмжээг бага байлгах мөн хөрс хуулалтын ажилтай зэрэг нөхөн сэргээлтийн ажлыг явуулах давуу талтай бөгөөд энэ нь байгаль орчин, эдийн засгийн үзүүлэлтэнд эерэгээр нөлөөлнө.

2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд өмнөх онуудад олборлотын явцад олборлолтонд өртсөн талбайг дотоод овоолгоор нөхөн дүүргэсэн ба олборлолт дууссаны дараа дахин бульдозер, экскаватороор тэгшилгээ хийж хэлбэршүүлэн нягтаршуулсан. 2017 онд нийт эвдэрсэн талбайн 1,07 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн. 2018 онд 0,17 га газарт олборлолт хийгдэж 0,17 га газрыг техникийн нөхөн сэргээлт хийсэн.

2019 онд 0,17 га газарт олборлолт хийгдэж 0,19 га газрыг техникийн нөхөн сэргээлт хийсэн.

2020 онд “Нөхөн сэргээлт-2020” мэдэгдлийн хүрээнд 0,3 га, техникийн нөхөн сэргээлт 0,2 нийт 0,5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.

2022 онд 5.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж хүлээлгэн өгсөн.\

2023 онд 0.5 га талбайд биологийг нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зардалууд	Хийсэн ажил	Гарсан зардал мян.төг
Ажилчдын цалин хөлс /8-9 сар	Техникийн нөхөн сэргээлт	1500.0
Материал	Биологийн нөхөн сэргээлт	1000.0
Нийт		2500.0

4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр мод тарихаар төлөвлөсөн боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй зогсонги, хөрөнгө мөнгөнөөс

шалтгаалж дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх боломжгүй болсон.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ,НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбай, түүний ойролцоо айл өрх байхгүй учир төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажил гарахгүй.

6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ

Төслийн талбайд одоогоор газрын гадаргад ил харгадах түүх, соёлын дурсгалт зүйл, археологийн олдвор байхгүй. Гэсэн хэдий ч төслийн үйл ажиллагааны явцад газрын хэвлийгээс түүх, дурсгалын зүйл илэрч болзошгүй тул нийт ажилчид, жолооч нарт анхааруулан, илэрсэн тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож орон нутгийн удирдлага, цагдаагийн байгууллагад мэдэгдэн, эрдэм шинжилгээний байгууллагад хандах хэрэгтэй гэдгийг зааварчилсан.

7.ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэн гардаг.

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол, эрсдлийн талаар	Гүйцэтгэсэн ажил	Зарцуулах зардлын хэмжээ мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Уурхай усанд автах, тоног төхөөрөмж урсах, машин техник шавар шалбаат суух, хүний амь эрсдэх, гэмтэх бэртэх, дэд бүтэц	Уурхай, эргэлтийн усан сан болон бусад шаардлагатай газруудыг тойруулан үерээс хамгаалах суваг шуудуу ухсан.	-	Олборлолт эхлэх үеэс

эвдэрч сүйдэх, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай усанд урсах			
Хүчтэй салхи шуурганы улмаас тоос ихээр босч ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоож ажилласан	Дотоод төлөвлөлтөөр	Үйл ажиллагааны турш
Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, дэд бүтцийн байгууламж эвдэрч сүйдэх, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоосон.	-	7-р сард
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг сард 1 удаа зохион байгуулсан. Осол аваар гарсан үед үзүүлэх анхан шатны тусламжийн эмийн сан байрлуулсан.	-	Ажил эхлэхэд
Уурхайн тоног төхөөрөмж эвдрэх, машин техник мөргөлдөх, хүн амьтан гэмтэж, бэртэх гэх мэт осол аваар гарах	Аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдаж, уурхайн ажилчид, жолооч нарт хичээлийг зааж, даатгалд хамруулсан	-	Үйл ажиллагааны турш
Уурхайд хүний болон байгалийн гамшигт үзэгдлийн үеэр гэнэтийн аваар осол	Гэрээ байгуулаагүй, гарч болзошгүй гэнтийн осол аваарийн үед бэлэн байдалд ажилласан.	-	Үйл ажиллагааны турш

гарч болзошгүй			
Нийт дүн		0.0	

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанд ямар нэгэн химийн бодис ашиглахгүй тул үйлдвэрлэлээс аюултай хог хаягдал гарахгүй.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын талаар	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж
Хатуу хог хаягдал болон бохир усыг төвлөрсөн цэгт зайлуулах	Хатуу хог хаягдал болон бохир усыг төвлөрсөн цэгт зайлуулах гэрээг Налайх Тохижилт Үйлчилгээний газартай байгуулсан	450.0	4 сард
Хог хаягдлын үүсвэр дээр нь ангилах нь хог хаягдлыг дахин ялгах	Хог хаягдал ангилан ялгах зориулттай хогийн савнуудыг шаардлагатай газруудад байрлуулсан.	-	Ажил эхлэх үед
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хог хаягдлаар хөрс, газрын доорхи ус бохирдох	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаасан.	50	2 улиралд
	Дугуй, модны хаягдлыг орон нутгийн хэрэгцээнд өгөх		
	Хаягдал төмрийн цэгт автомашины сэлбэг, төмрийн хаягдлыг тушаах		Жилд 1 удаа 10-р сард
	Цаасны хаягдлыг хаягдал цаас боловсруулах үйлдвэр, цэгт тушаах		
	Тослох, материал, бензин тосоор бохирдсон хөрсийг тусад нь ялгаж авч тусгай талбайд байршуулан саармагжуулан цэвэрлэх арга хэмжээ авч ажилласан		
Нийт дүн		500.0	

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИЛЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тоосгоны үйлдвэрийг ажиллуулах болон тоосгоны шавар олборлосноос үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, Хяналт-шинжилгээ хийх хуваарь, давтамж, сорьц дээж авах цэгийн байршил, баримтлах стандарт, түүнийг тодорхойлох арга аргачлал, шаардагдах зардлыг тооцож, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллагад бодитой мэдээлэл өгөх зорилготой.

Жил бүр тухайн жилд хийгдсэн Хяналт-шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж байх нь цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналтын цэгийн байршил оновчтой эсэх, объектыг бүрэн хамарч буй эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Үйлдвэрлэлийн процесст хийгдэж байгаа Хяналт-шинжилгээний зорилго нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед гарах хаягдал болон бусад төрлийн бохирдуулагчдыг алдагдах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, оновчтой үзүүлэлтүүдийг сонгон авч хянах, урьдчилан харах бололцоогүй гэнэтийн осол гарсан тохиолдолд түүний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь оновчтой байхад чиглэгдэнэ

**ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР				
Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM2.5, PM10 Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: TSP, SOX, NOX, COX	-Тоосгоны үйлдвэр - Конвейерын орчим	Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид хандаж ажлын байрны агаар тоосны нэг удаагийн болон хоногийн дундаж хэмжээг тодорхойлуулсан.	58.0	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,
2. УСНЫ ЧАНАР				
Ахуй, үйлдвэрийн зориулалтаар ашиглах худгийн усны шинжилгээг өгөх	Тоосгоны үйлдвэрийн орчимд	ШУА-ийн Газарзүй –Геоэкологийн хүрээлэнд	50.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS(ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3. ХӨРСНИЙ ЧАНАР				

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хөрсний бохирдох	Тоосгоны үйлдвэрийн орчимд	ШУА-ийн Газарзүй – Геозкологийн хүрээлэнд Хөрсний шинжилгээ	50.0	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
4. УРГАМЛАН ХӨМРӨГ				
-Хяналтын талбай дахь ургамлын төрөл зүйл,орчинд бүрхэц %, бодгалиудын тоо; -Ургамлын дундаж өндөр, см; -Газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га;	-Тоосгоны үйлдвэрийн болон - Олборлолт ын талбайн орчинд	Мэргэжлийн байгууллагатай тохиролцон жил тутам -Байрлал тогтоох багаж GPS -Компас -Налуу хэмжигч -Дижитал фотоаппарат -Туузан метр, 50 м урттай -Хатгуур, 50 см урттай г.м	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
5. ДУУ ЧИМЭЭ БА ДОРГИО ЧИЧИРГЭЭ				
-Гадаад орчны дуу чимээ -Ажлын байрны дуу, чимээ	Тоосгоны үйлдвэрийн орчинд Дуу чимээ, доргио чичиргээ бүхий ажлын байранд	Улиралд 1 удаа	-	Дэлхийн Банкны дуу чимээний стандарт
6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ				
-Ажилд орохоос өмнөх эрүүл мэндийн үзлэг, -Эрүүл мэндийн явцын үзлэг, -Ажлын байрны нөхцөл (агаар, гэрэл, тоос, дулаан, чийг, үнэр, чимээ болон бусад шаардлагатай үзүүлэлтүүд)	Тоосгоны үйлдвэр	Жилд нэг удаа	800.0	Ажлын байрны болон эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийн болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол Улсын стандартууд
Нийт зардал			958.0 /төг	

10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Налайх дүүргийн Засаг даргын тамгын газраас гаргасан зохион 10 шар байрны урд талд хүүхдийн тоглоомын талбайн тохижилтонд 1500.0 мян.төг-ийн хандив өгсөн.

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Гарсан зардал мян төг	Хариуцагч
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт ШИНЖИЛГЭЭНИЙ хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдүүлсэн.	Төслийн нийт хугацаанд	Дотоод зардал	БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн
2.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлсэн.	Жил бүрийн 11-р сард		БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн
3.	Байгаль хамгаалахад дүүргийн Иргэдийн оролцоог идэхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Налайх дүүргийн 3-р хорооны иргэдийн дунд уулзалт хийж Байгаль Орчин нөхөн сэргээлтийн асуудлаар санал хүсэлт солилцсон.	Жил бүрийн 6-р сард		БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн
4.	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг заасан хугацаанд хийх мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	“Эковишн” ХХК-аар байгаль орчны аудит хийлгэсэн.	2020	-	БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн
5.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	Заасан хугацаанд хийх	2020		БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн

**12. БОМТ-Г ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ,
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

БОМТ-г хэлэлцүүлэх оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Иргэд, хорооны ИНХ	Хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэх, санал авах	хийгдээгүй	-	Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар санал	-
	Ажлын тайланг хянуулж, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний чиглэлээр хийгдэж буй ажил	2023 оны 11-р сарын 01-нээс өмнө	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	БОАЖЯ

2023 онд БОМТ хэрэгжүүлэхэд хийгдсэн ажил, зардал

2023 онд уулын ажил болон тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаагүй бөгөөд зөвхөн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

	Хийгдсэн ажлууд	Зардал / төг /	Хариуцсан ажилтан
1.	Сөрөг нөлөөллийг бууруулахад	1000.0	Г.Уранбилэг
2	Нөхөн сэргээлт	2500.0	
2.	Дүйцүүлэх нөхөн сэргээлт	0.0	Г. Уранбилэг
3.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд	0.0	О. Мөнхтулга
4.	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлтэнд	500.0	Б. Мөнхцэцэг
5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтэнд	158.0	Б. Мөнхцэцэг
	ДҮН	3958.0	

Байгаль орчин хамгаалах зардалд нийт 3958.0 мянган төгрөг зарцуулсан болно.

